

**"ЭМИЙН НЭРСИЙН ДАЛАЙ" ЭРТНИЙ СУДРЫН ЗОХИОГЧИЙН НАМТАР,
БҮТЭЭЛИЙГ ТОДРУУЛАХ АСУУДАЛД**

Т.Цэцэгдарь¹, Г.Энхжин², Э.Сансархуяг², Л.Түдэвдагва²,
Т.Ариунжаргал², Б.Одончимэг², Ш.Болд³, Б.Буянт¹

¹ "Өвөр монголын үндэстний их сургууль"

² "Эм зүйн шинжлэх ухааны их сургууль",

³ "Монголын анагаах ухааны академи"

Email: yukiandtara@gmail.com

Утас: 89922017

Abstract

**CLARIFYING THE AUTHOR'S BIOGRAPHY OF THE ANCIENT BOOK
"THE OCEAN OF MEDICINAL NAMES"**

Tsetsegdari.T¹, Enkgjin.G², Sansarkhuyag.E², Tudevdaagva.L²,
Ariunjargal.T², Odonchimeg.B², Bold.Sh³, Baoyintu Bai¹

¹ Inner Mongolia University for the Nationalities,

² Mongolian University of Pharmaceutical Sciences,

³ The Mongolian Academy of Sciences

Email: yukiandtara@gmail.com

Starting in 2019, the project "To compile and publish 108 volumes of traditional medicine, to protect the heritage of the ancient medical sources, and to open up its commercial opportunities for use" has been implemented.

As a result of this project, 50 volumes of books were published, including books created by Mongolian ancient doctors and maarambas, translated medical books from Chinese, Manchu, and Tibetan, as well as some books written by traditional medicine researchers and scientists between 1990-2020, have been published and made available to the public. During the creation of 108 volumes of traditional medicine, dozens of ancient medical scriptures were newly discovered. Among them, we have found medicinal books written by Indian and Tibetan scholars and monks from the 8th and 13th centuries. One of them is The Third Karmapa, Rangjung Dorje's sutra, "The Ocean of Medicinal Names." Therefore, it is imperative that we first study the biography and works of The Third Karmapa, Rangjung Dorje.

Purpose: Clarifying the biography and works of The Third Karmapa, Rangjung Dorje, the author of the book "The Ocean of Medicinal Names."

Research methods: Research of source documents (ancient sources), hermeneutic approach, analysis, and synthesis methods were used.

Conclusion: 1. The Third Karmapa, Rangjung Dorje, who lived between 1284 and 1339, was a prominent Tibetan religious and cultural figure, a famous author of many books who contributed to strengthening the foreign relations between Mongolia and Tibet and increasing the influence of the Garmaa Gaajud tradition in Yuan Dynasty.

2. Although Karmapa, Rangjung Dorje lived at the end of the 13th century and the first half of the 14th century, he was a well-known, active and creative monk. Therefore, his image has been left in many paintings and cast as God's image. In particular, he wrote an interesting book about medicinal raw materials called "The Ocean of Medicinal Names," which has only a few pages but briefly contains the names and potencies of 768 medicinal raw materials.

Keywords: raw materials, medicinal names, The Third Karmapa, and Rangjung Dorje

Удиртгал

Нүүдэлчдийн тэжээхүй ухааны гол цөм болсон Монголын уламжлалт анагаах ухаан нь өвөг Монголчуудын оюун билиг, хичээл зүтгэл, амьдрал практикаар шалгагдан шигшигдэж, цаг хугацааны урт шалгуурыг даван, олон зууныг туулан ирэхдээ хөгжин цэцэглэх, гандан буурах түмэн нугааг даван 5000 жилийн хөгжлийн түүхэн замыг туулжээ. Түүхийн энэхүү урт хугацаанд өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэргийлэх олон арван аргыг агуулсан хэдэн зуун судар номыг бүтээж чадсан байна¹.

2019 оноос эхлэн “Уламжлалт анагаах ухааны 108 ботийг эмхэтгэн хэвлүүлэх, сурвалж бичгийн өвийг хамгаалах, ашиглах түүний арилжааны боломжийг нээх” төсөл хэрэгжиж монгол эмч, маарамба нарын туурвисан, төвөд, хятад хэлнээс орчуулсан, уламжлалт анагаах ухааны эрдэмтэн судлаачдын бичсэн 50 ботийг өлгийдөн авч нийтийн хүртээл болгоод байна². Уламжлалт анагаах ухааны 108 ботийг бүтээх явцад анагаах ухааны нэн эртний олон арван судар номыг шинээр олж тогтоосны дотор өмнө нь судлагдаж байгаагүй Энэтхэг, Төвөдийн эрдэмтэн лам нарын 8 дугаар, 13 дугаар зууны үеийн төвөд хэлээр буй хэдэн хэдэн эмийн ном олдоод байна. Үүний нэг нь Гармава Ранжүндоржийн “Эмийн нэрсийн далай” хэмээх судар юм. Энэ судар нь ургамал, амьтан, эрдэс зэрэг нийт 768 эмийн түүхий эдийг багтаасан, хуудас нь цөөн ч, агуулга нь баялаг ном юм. Тиймээс Монголын уламжлалт анагаах ухааны эм судлалд ихээхэн ач холбогдолтой ном болох нь дээр дурдсан эмийн тооноос харагдаж байна. Уг судар эхлэхдээ: “Ялгуусан ринсрэл (ring bsrel) бол эрднийн эмийн дээд болох бөгөөд хүсэл бүгдийг хангаж, ном айлдагч, өөрөө ялагч, бодисадва, түүнчлэн егүзэр нарын шарилыг тахих буюу биедээ

хадгалваас ад чөтгөр бүхэнд хорлогдохгүй. Зэндмэнэ эрдэнэ биндэрья нь гэрлээрээ өвчин бүгдийг арилгана. Индранил өвчин бүгдийг арилгана. Очир эрдэнэ (алмаас)-ээр тогтор бүгдийг хариулна. Бадмааргаар өвчин бүгдийг хариулна. Маргад эрдэнэ өвчин бүхэнд тустай. Муурын нүд хэмээх эрдэнэ аварга могойг буцаана. Усан болор халууныг амарлиулна. Галт болор хүйтэн өвчнийг дарна. Гаргада (ཀར་ཀར་ кара kakra)-аар хатгалгааг дарна. Вүрлэн буюу хув (སུར་ལེན sbura len) хорын халуун бүгдийг дарна. Тэр ховор эрдэнийн чулуу арван зүйл буй”³ хэмээдэг. Эдгээр эрдэнийн эмээс үзэхэд эмийн хэрэглээг энэхүү сударт зөвхөн эмийн нэрээс гадна юунд, ямар өвчинд хэрэглэдэг талаар товч бөгөөд тодорхой бичсэн нь практикийн ач холбогдолтой байна. Тиймээс уг судрыг төвөд хэлнээс орчуулж судлахаас гадна зохиогчийн намтрыг тодруулахаар энэхүү судалгааг хийлээ.

Зорилго

“Эмийн нэрсийн далай” судрын зохиогч Гармава Ранжүндоржийн намтар, бүтээлийг тодруулах.

Зорилт

1. “Эмийн нэрсийн далай” судрын зохиогч Гармава Ранжүндоржийн намтрыг төвөд, англи хэлээр бичсэн эх сурвалжид тулгуурлан тогтоох,
2. Гармава Ранжүндоржийн зургийн учир холбогдол, анагаах ухаанаас гадна өөр ямар ямар бүтээл байгааг судлан тодруулах.

Судалгааны арга

Судалгаандаа дараах аргуудыг ашиглав. Үүнд:

1. Эх бичиг, сурвалж бичиг судлалын арга

Бид судалгаанд ашигласан материалаа ажлынхаа зорилго, зорилтуудад нийцүүлэн

зохиогчийнх нь төрсөн болон амьдарч байсан цаг хугацааг хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлж, намтар, түүхийн судалгааг хийж улмаар бүтээлийн гол агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг, эргэлт гарахуйц санааг бусад эх зохиолуудтай харьцуулан, шүүн тунгааж үзлээ. Мөн зохиолын дотор агуулагдах эмийн ухаантай шууд холбоотой мэдээ, сурвалжийг сонгон авч цаг хугацааны дараалалд оруулан бусад бүтээлийн мэдээллээр баяжуулан оюун дүгнэлт хийв.

2. Анализ, синтезийн арга

Анализийн арга нь судалж буй материалаа хэд хэдэн хэсэгт хуваах, задлан шинжлэх үйлдлүүд юм. Ингэснээр судар, номын бүтэц, гол шинж, түүнийг бүрдүүлж буй хэсэг хоорондын холбоо, онцлог, давуу, сул талыг тогтоож болдог. Синтезийн арга нь анализийн аргатай холбоотой хамтдаа хэрэглэгдэнэ. Уг арга нь задалсан хэсгийг эргээд оновчтой байдлаар холбон нийлүүлэх үйлдэл юм. Энэ аргыг бүтээлчээр хэрэглэснээр "Эмийн нэрсийн далай" эртний судрын зохиогчийн талаар урьд өмнө нь мэдээлэгдэж байгаагүй шинэлэг зүйл баримт материалыг олж тогтоов.

3. Герменевтик арга

Герменевтик гэдэг нь тайлбарлах, хөрвүүлэх гэсэн грек үгнээс гаралтай, эрт үеийн ном судрууд, соёлын дурсгалт зүйлүүдэд утгын тайлал хийх, тайлбарлах, орчуулах зорилгоор герменевтик арга зүйг боловсруулжээ. Бид герменевтик аргаар "Эмийн нэрсийн далай" судрын зохиогч Гармава Ранжундоржийн амьдрал, цаг үеийг судалж задлан шинжлэх, намтар бүтээлийн талаарх мэдээлэл цуглуулж, учир шалтгааныг нь тайлбарлан тодруулав.

Судалгааны үр дүн, хэлцэмж

1. Гармава Ранжундоржийн намтрыг эх сурвалжид тулгуурлан тогтоох нь

Гармава Ранжундоржийн намтрын талаар Лама Жавжи Зомдагжагийн "Төвөдийн мэргэдийг зэргэмжээр дараалуулсан анагаах ухааны бүтээлийн эмхэтгэлийн гарчиг сувдан эрхис"⁴ ном, Blo bzang chos grags dang bsod nams rtse mo (1988-1989) Karma rang byung rdo rje "In Rtsom yig gser gyi sbram bu"⁵, Chos grags ye shes "Dpal karma pa rang byung kun mkhyen chos grags rgya mtsho'i zhabs la bstod pa'i phreng ba rnam"⁶, Douglas, Nik, and Meryl White. Karmapa - The Black Hat Lama of Tibet⁷, Jackson, David. 2009. "The Black Hats of the Karmapas." In Patron and Painter; Situ Pañchen and the Revival of the Encampments Style⁸ зэрэг бүтээлүүдээс эмхэтгэн авлаа.

Монголоор Гармава Ранжундорж, төвөдөөр Karmapa Rangbyung rdorje нь 1284 он буюу билгийн тооллын модон бич жилийн 1-р сарын 8-ны өдөр дээд Төвөдийн Запуганшүрма (tsaphu gangs zhur mo) гэдэг нутагт мэндэлжээ. Түүний аавыг Чойбал (chos dpal) гэдэг бөгөөд Нимавагийн урсгалыг шүтдэг, өдөр бүр залбирал үйлддэг, өөрийн хүүдээ шижэ сургаалийг даган соёрхохыг хэлдэг нэгэн байв. Ээжийг нь Жомояндрэн (jo mo g.yang 'dren) хэмээдэг. Бага байхад нь эцэг, эх нь түүнийг Цан (Tsang) хотод мөргөл үйлдэхээр авч явсан төдийгүй Жидрон (skyid rong) дахь зандан модоор урласан алдарт Мэгжид Жанрайсиг (Avalokiteśvara) бурханд мөргүүлжээ. Энэ нь түүнд ихээхэн сэтгэгдэл төрүүлж бурхны шашинд итгэх, ном эрдэм сурах анхны шанг татсан гэдэг. Улмаар таван настайдаа Вүддрасан (sbud tra sang) хийдэд очиж Ожанба Ринченбал (o rgyan pa rin chen dpal, 1229-1309)-аас анхны сахил хүртэж, олон тооны тарнийн номыг удиртгалыг сонссон байна. Зарим эх сурвалжийн ёсоор бол Ожанба Ринченбал бага насны хүүг хараад өөрийн багш, хоёр дахь Гармава, Гармаа Пакши (Карма Пакши, 1203/04-1283)-ийн хойд дүр мөн байна хэмээн

таньж тодорцуулаад, "Миний их багшийн нууц алдрыг Ранжүндорж гэдэг ээ, би энэ алдрыг чамд хайрлая" гэж зарлан тунхагласан гэдэг. Гэхдээ өмнөх үеийн зарим сурвалжид түүнд банди сахил өгсөн Гүнданшэрав (kun ldan shes rab) багш Ранжүндорж гэдэг алдрыг хайрласан гэж бас тэмдэглэсэн байдаг. Чухамдаа ихэнх эрдэмтэд Ранжүндорж өөрийнхөө итгэл үнэмшлээр өөрийгөө Гармаа Пакшийн хойд дүр мөн гэж баталсан. Үүгээр ч зогсохгүй анхдугаар, хоёрдугаар Гармавагийн алдрыг хайрласан Дүйсүмчэнба (dus gsum mkhyen pa, 1110-1193)-гийн дахин төрөлтийг ялган таньсан байна.

1294 онд 10 насныхаа төрсөн өдрийн өмнө Ранжүндоржид сахиуснаас нь тухайлбал шашныг хамгаалагч гол Чойжин бөгөөд Жанрайсиг бурханы догшин дүр Махагал буюу Гомбо сахиус түүнд Цүнпү (mtshur phu) рүү очиж Дүйсүмчэнба болон Гармаа Пакшийн суудалд залрахыг зөгнөн хэлжээ. Хэлсэн ёсоор Цүнпүд очиж Шэравбал (shes rab dpal), Нянрайгэндүнвүм (gnyan ras dge 'dun 'bum) болон Намцовамижоддорж тэргүүтэн багш нараас олон янзын ном, эрдмийн үүн дотор калачакра, чодын сургаал, авшиг, лүн хүртжээ.

1301 онд 18 насандаа хамба ламын үүрэг гүйцэтгэгч Шоннүжанчүв, ёс журмын үүрэг гүйцэтгэгч Гэндүнринчен нараас бүрэн сахил авчээ. Түүнчлэн Санпү хийдийн хамба Шагжшоннүгийн хамт буддын сүм хийдэд судалдаг мэдлэг ухааны Прамана, Пражнапарамита, Мадхьямака, Абхидхармакоша, Виная гэсэн 5 стандарт бүтээлд сайтар суралцжээ. Тэрбээр Недогүнгаадондүв (snye mdo kun dga' don grub, 1268) багшаас Падамба Санжай (pha dam pa sngs rgyas, 1117) болон Ожанба нарын бүрэн ном, сургаалыг хүлээн авч мөн Гармаа Гаажүдийн уламжлалын зааврыг Зогдан

Намцо (rdzogs ldan gnam mtsho) ламаас уламжлан авчээ.

Дараа нь тэрбээр 1147 онд Дүйсүм Чэнбагийн байгуулсан Хам дахь Гармагонд очиж, Лхатэнгийн даяанчийн агуйг (lha steng) байгуулсан байна.

Үйзанд буцаж ирээд Жохан дахь Жово гэгээний хөшөөнд шүхэр хандивлаж, маргаан мэтгэлцээнийг шийдвэрлэхийн тулд Конпо руу богино хугацаагаар аялжээ.

Ранжүндорж, Цүнпү хотод алтадмал дээвэртэй сүм барьж, Дүшид Дэчэндэн гэдэг даянчийн хийд байгуулав. Тэрбээр Гунгаадондовоос калачакрагийн сургаал, олон тооны тарнийн авшиг хүртэж боловсролоо үргэлжлүүлэн дээшлүүлж улмаар Варай ламаас анагаах ухааны шүн, шүнгийн тайлбар, тарнийн уламжлалыг Цүлтимринчен, Зогчэннинтиг, Ригзингүмарараза (1266-1343) нараас мөн Рихоррайбагаас тус тусад нь авчээ. Дараа нь дахин Конпод очиж, тэнд гурван жил суужээ. Үүний зэрэгцээ Хар даянчийн агуйн хийд, хэд хэдэн хийд орон байгуулж, ууланд даян хийж байв.

1326 онд Ранжүндорж, Үйзанд буцаж ирээд, Цэлпа болон Гармаа Гаажүдийн урсгал хоорондын маргааныг зуучилж, сургаал айлджээ. Үүний дараа тэрбээр дахин зүүн тийшээ явж, Гармаа Гоны зүүн талд буй Согчу (сог чу; Салвины зүүн эргийн цутгалан) дээгүүр төмөр гүүр барьж дуусаад Конпо уруу бууж, Нагпуд даян хийв. Үүний зэрэгцээ Долбоба Шэравжалцан (dol po pa shes rab rgyal mtshan, 1292-1361)-тай уулзсан бөгөөд үүнийг хожмын түүхчид, тухайлбал Жамгон Гонбрүл ('jam mgon kong sprul, 1813-1899) Ранжүндоржийг Шандоны үзлийг дэмжсэн гэж үздэг.

Ранжүндорж 1331 онд Үйзанд буцаж ирсэн бөгөөд тэр жил Юань Улсын эзэн хаан

Төвтөмөрөөс (1328-1332 онд) Дадугийн эзэнт гүрний нийслэл буюу одоогийн Бээжин хотод айлчлах урилга хүлээн авчээ. Тэрбээр 1332 оны 11 дүгээр сарын 6-нд нийслэлд хүрэлцэн ирэв. Төвтөмөр хаан, Ранжундоржийг замдаа явж байхад нь нас барж, түүний залгамжлагч Ринчинбал хаан Гармаа ламыг нийслэлд байхад мөн нас баржээ. Тэрбээр хаан ширээг залгамжлагчдын маргааныг зуучилж, Тогоонтөмөр (1333-1370 он) хааныг Шанду хотод хаан ширээнд залрах үед байлцсан байна. Нийслэлд байхдаа шинэ хаанд шашны чиглэлээр зөвлөгөө өгч, Цал Гүнтангийн хамба лам, өөрийн шавь Гунгаадоржид (kun dga' rdo rje, 1309-1364) Ситу (Гурван чухал албан тушаалын нэг) болон Гуоши (Улсын багш) цол олгохыг баталгаажуулжээ. Цаашид Цүнпүүг татвараас чөлөөлсөн нь Монгол, Төвөдийн үйл хэрэгт Гармаа Гаажүдийн уламжлалын нэр нөлөөг улам бүр өсөн нэмэгдүүлж байгааг нотлох гайхалтай ололт болсон юм.

1334 онд Ранжундорж Хятадаас гарч, Утай уул, Миняк, Мархамыг дайран, дараа жил нь Цүнпү хотод хүрч ирэв. Тэр жилийнхээ өвлийг Самья хийдэд өнгөрөөсөн. Хоёр жилийн дараа буцаж ирнэ гэж амлаж байж Хятадаас гарах зөвшөөрөл авсан тэрбээр Төвөдөд ирээд удаагүй байхдаа Хятад руу 1336 онд буцаж, 1337 онд Даду хотод иржээ.

1338 онд улсын түшмэдүүдийн цуглаан дээр тэрбээр "Би иогчин хүн, би бол үүл шиг" гэж өөрийгөө зарлан сонордуулсан байна. Түүнчлэн "Миний сургаалын утга учрыг ойлгохыг хүссэн бүх хүмүүс үүнийг хурдан ойлгох болтугай" хэмээн айлджээ. Ингээд жил хүрэхгүй хугацааны дараа буюу 1339 оны туулай жилийн тавдугаар сарын тавны бэлгэт сайн өдөр тэнгэрт хальжээ.

2. Гармава Ранжундоржийн зургийн учир, бүтээлийн талаарх баримтууд

Гуравдугаар дүрийн Гармава Ранжундоржийг бурханчлан зурсан хэд хэдэн зураг, цутгамал бурхан бий. Зургийг нь хар цагаан, өнгөт гээд хоёр үндсэн хэсэгт хуваана. Хар, цагаан зураг үндсэндээ 2-3 янз байдаг. Харин өнгөт зураг олон янзаараа байна. Үүнээс бид Translating the Karmapas' works гэсэн вэб сайтаас дараах зургийг сонгон авлаа⁹. Энэ зураг бол зохиогчийн эрхийг зөрчихгүйгээр ашиглах боломжтой бүтээл юм.



Гуравдугаар Гармава, Ранжундорж
1284 - 1339

Гурав дахь Гармаба Ранжундорж нь Доха, судрын тайлбар, зурхай, Чод, цадиг зэрэг өргөн хүрээтэй олон сэдвээр бүтээл туурвисан. Түүний Махамудрагийн тухай хэд хэдэн бүтээл, тухайлбал, "Махамудрагийн тодорхой утгын алдарт залбирал" (nges don phyag rgya chen po'i smon lam) нь сонгодог бүтээл хэвээр үлджээ. Өөр нэг алдартай бүтээл нь 1322 онд Дэчэн Тэн хэмээх агуйн сүмдээ бичсэн "Анuttара иогын тарнийн тайлбарын гүн гүнзгий утга" хэмээх судар болно. Түүний алдартай зарим

зохиол нь "Ранжундорж" хэмээх өөрийн гарын үсгээ зурсан Гармаа Пакшигийн бүтээл байж магадгүй хэмээн үздэг.

Дээр дурдсан зохиолуудын дотор Гармаба Ранжундоржийн анагаах ухааны тухайлбал эмийн ухааны чиглэлээр бичсэн сонирхолтой судар бий. Энэ номыг Лама Жавжи Зомдагжа бичиж, 1997 онд Гансу мужийн Ард түмний хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн "Төвөдийн мэргэдийг зэргэмжээр дараалуулсан анагаах ухааны бүтээлийн эмхэтгэлийн гарчиг сувдан эрхис" номонд Ранжундоржийн намтар, "Эмийн чадлыг нэгэн зүгт үзүүлсэн эмийн нэрийн далай хэмээх оршивой" (sMan gyi nus pa phyogs gcig tu bstan pa sman ming rgya mtsha zhes bya ba bzhugs so) бүтээлийн талаар товч оруулжээ. Энэ сударт нийт 768 эмийн түүхий эдээс ургамал 462 (60.2 %), эрдэс 130 (17%), амьтан 91, 127 түүхий эд (16.5%), шимийн эм 23 (3%), усан эм 26 (3.3%) байгааг бид тогтоогоод байна.

Дүгнэлт

1. Гуравдугаар Гармаба, гармаа Ранжундорж нь 1284-өөс 1339 оны хооронд амьдарч байсан Төвөдийн шашин, соёлын нэрт зүтгэлтэн зохиолч, Монгол, Төвөдийн гадаад харилцааг бэхжүүлэх, Гармаа Гаажүдийн уламжлалын нэр нөлөөг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан хүн байжээ.
2. Хэдийгээр Гармаа Ранжундорж 13 зууны сүүлч 14 дүгээр зууны эхний хагаст амьдарч байсан ч нэр хүндтэй, ажил үйлс, бүтээл туурвил арвинтай лам байсан учир дүр төрх нь зураг, цутгамалд олонтоо бууж үлдсэн байна. Ялангуяа анагаах ухааны талаар товчилбол: "Эмийн нэрсийн далай" гэдэг цөөн хуудастай боловч 768 эмийн түүхий эдийн нэр, чадлыг товч оруулсан сонирхолтой бэсрэг ном бичсэн нь бидний үе хүртэл уламжлан ирсэн байна.

Ном зүй

1. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006
2. Ш.Болд, Д.Цэрэндагва. Жаран өнгөрсөн ч үл мартагдах номын суварга. <https://news.mn/r/>
3. Гармава Ранжундорж. "Эмийн нэрсийн далай"
4. Лама Жавжи Зомдагжагийн "Төвөдийн мэргэдийг зэргэмжээр дараалуулсан анагаах ухааны бүтээлийн эмхэтгэлийн гарчиг сувдан эрхис"
5. Blo bzang chos grags dang bsod nams rtse mo. 1988-1989. Karma rang byung rdo rje. In Rtsom yig gser gyi sbram bu. Xining: Mtsho sngon mi rigs dpe skrun khang, vol. 1, pp. 219-222. TBRC W19680.
6. Chos grags ye shes. Dpal karma pa rang byung kun mkhyen chos grags rgya mtsho'i zhabs la bstod pa'i phreng ba nams. In Gsung 'bum / chos grags ye shes. Beijing: Krung go'i bod rig pa dpe skrun khang. TBRC W1KG4876. 2009.
7. Douglas, Nik, and Meryl White. Karmapa - The Black Hat Lama of Tibet. London: Luzac & Company LTD. 1976
8. Jackson, David. "The Black Hats of the Karmapas." In Patron and Painter; Situ Pañchen and the Revival of the Encampments Style, pp. 39-69. New York: Rubin Museum of Art. 2009
9. Translating the Karmapas' works. <https://www.translating-karmapas.org/>
10. g.Yu thog yon tan mgon po sogs. sngo 'bum sman gyi gtera mdzod. Kan su'u Mi rigs dpe sgrun gang, 2006
11. bLa ma sKyabs kyis rtsom bsgrags byas. Bod kyi mkhas pa rim byon gyi gso rig gsung 'bum dkara chag mu tig phreng ba. Kan su'u Mi rigs dpe sgrun gang, 1997

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор, дэд профессор
Б.Цэрэндогзор